



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 4/221

Мандалговь

“Гео зураглал” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 33 дугаар зүйл 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Дэлгэрхангай сумын Засаг даргын тамгын газрын гадна талбайн зураг, төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажилд ирүүлсэн үнийн саналаар “Гео зураглал” ХХК-тай 8,000,000 (найман сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан ажлын даалгаврын дагуу Дэлгэрхангай сумын Засаг даргын тамгын газрын гадна талбайн зураг, төсөв боловсруулах ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Гео зураглал” ХХК-ны дэд захирал (Ж.Батнасан)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Дэлгэрхангай сумын Засаг дарга (М.Батсүх), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4862111-4